

НЭЙЖ ТОЙН ХУТАГТ

Д.Ганбаатар – МУИС. НШУС, Шашин судлалын тэнхим, докторант



Түлхүүр үг: Чойжи-Одсэр, монгол уншлага, аялгуу хэмнэл, эх монгол хэл, уламжлал, Манзуширын хувилгаан, судар шастир, Авга хар уул, Харчин, егүзэр

Товч утга: Монголчуудын дунд монгол хэлээрээ бурханы шашны уншлага, зан үйлийг үйлддэг уламжлал эртнээс нааш байсаар ирсэн бөгөөд ийнхүү уламжлагдан үлдэхэд монголын сэтгэгч Нэйж тойны оруулсан нэмэр хандив, гүйцэтгэсэн үүргийн талаар эл өгүүллэгт бичсэн болно.

Бурханы ном судрыг үндэсний бичиг, хэл соёлоороо дэлгэрүүлэх, хурлын уншлага зан үйлийг монгол хэлээрээ урих үйлийг үндэслэж, ёс дэг журмыг тогтоон, тууштай зүтгэн дэлгэрүүлсэн хүн бол Нэйж тойн Авид (1557-1664) хутагт болой. Тэрбээр дөрвөн Ойрадын торгууд аймгийн ноён мэргэн Тэмнангийн хөвгүүн болж заяажээ.

Багаас лам гурван эрдэнэд туйлын сүсэгтэй Авид ертөнцийн эгэл амьдарлаа

огоорон эцэг эхийн хорио харгалзалаас мултран гэрээс оргон бурханы ариун дагшин номын орон гэгдэх төвдийн зүг оджээ. Тойн хутагтын эгэл амьдралаас салж, лам болохоор сэтгэл шулуудсан тухай намтарт “тэрбээр олон нөхөр сэлтийн хамт ан хомрого авлахаар одохуй дор төрөх шахамдсан зээрийн хэвлийг харваснаар гарах зулзага ану унаж, тарчилж хэвтэхүй дор эх ану унагаа хэлээрээ долоохыг үзэж, сэтгэл уйдаад тойн болох санаа өвөрлөв”¹²⁴ гэдэг. Нэйж тойн Торгууд ханы ганц хөвгүүн байсан бөгөөд эцэгтээ лам болох тухай айлтгахад эцэг нь эрс татгалзан, уурлаж, түүнийг лам болгохгүйн тулд эхнэр авч өгчээ. Тэгэвч Тойн гэгээн сэтгэл хоргодсонгүй өдөр ирэх бүр тойн болох гэж зүтгэсээр байсанд эцэг нь дийлэн үл ядаад арга мухардахдаа хүнээр сахиулан харуул талбижээ. Нэгэн өдөр Авид гэрийнхээ гадаа суугаад ном үзэж байхуйд гэнэт хуй салхи гарч, уншиж байсан судрыг нь хийсгэжээ. Номныхоо хойноос хөөцөлдөж явсаар гэрээсээ нилээн холдсоныг нь сахисан хүмүүс алмайраад харалгүй өнгөрснийг ашиглан тэр чигтээ гэрээс гаран, гэргий хүүхдээ орхин баруун зүгт оджээ.

¹²⁴ “Богд Нэйж тойн далай манзуширийн домогийг тодорхой гийгүүлэгч чандмань эрхи оршивой”

Тэр цагийн жишгээр бодоход хэрэв язгууртны хүү болж төрсөн л бол өөрийн дураар сайхан амьдрах хувь тавилан заяасан нь ойлгомжтой. Тийм атал умбаж, шумбаж асан жаргалт амьдралаасаа жигшин зайлж, тойн болон эрдэм номын хойноос хөөцөлдөнө гэдэг бол бие махбодийн эр бял, эрх жаргалыг үнэн голоос огоорон, оюун ухааны тэнхээгээр хорвоог туулах ерөөл талбигсаны үр, эгэл бус нэгний зохиол гэж ойлгогдож болно. Бурхан багшийн намтар ч үүн лүгээ адил утгыг бидэнд ойлгуулдаг. Үүнийг Мэргэн гэгээн бээр:

“Хутаг хишиг олбориту жаргалангийн ордоньг

Хорт могойн үүр мэт айлдаад тэвчиж

Хотлыг аврагч Бурхан багшийн ёсоны

Хувцад иеэр чимэгсэнээ залбаримуй адисла”¹²⁵ хэмээн

магтжээ.

Нэйж тойн төвдийн Дашлхүнбэ хийдэд IV Банчин-эрдэнэ Лувсанчойжижанцанд (1570-1662) шавь орон суралцаж, олон мэргэн шидтэнийг шүтэж, охь судар, үндэс, тааллын тайлбар, их бага арван ухааны эрдэмүүдийг сурахын туйлд хүрч, ямандагийн үндэсний хоёр зэргийн оньсны утга дор үлэмжид мэргэшжээ. Төвдийн олон бандида нараас авшиг сэлтийг авч, улмаар хиргүй ариун аяга тахимлэгийн санваар хүртэн, шашны боловсролыг төгс эзэмшжээ. Нэйж тойн хутагт гэрээс гарч тойн болоод Монгол орноо буцаж ирэхдээ сүм хийдэд залран өндөр сэнтийд сууж, өнгөт магнагийг өмсөхийг урьтал болгосонгүй харин ч хадан агуйд сууж, өглөгийн идээг шүтэн, хармаг тармагийг өмсөж, хатуу бэрхийг эдлэн Өвөрмонголын Авга хар ууланд 12 жил, Шар малгайн агуйд 23 жил нийт 35 жил хатуу бэрхээр бясалгал даяан хийн суусан архад ажээ.

Тэрээр энэ олон жил хатуу дияанд суун, бясалгал хийснээр гэгээрлийн хутгийг олж, номын хүч чадлыг эзэмшин, эгэл ертөнцийн түвшнээс хэтийдэн, тарнийн ёсыг эзэмдэн (оюуны хүчээр тодорхой цэнэг хуримтлуулж, түүнээ хэрэглэн, бусдад нөлөөлөн үйлчлүүлж чаддаг), ёгын ухааныг төгс эзэмшээд, билгийн чанадын мөн чанарт нэвтэрч авидарма, судар, винайн гурван аймаг сав номд илт туулсан хутагт хүн юм байна гэж танигдаж байна. Түүний тарни номын хүчээр их рид хувилгаан, сонин гайхамшигийг илтэд үзүүлэн хаад ноёд, ихэс дээдсээс аваад эгэл борчууд хүртэл хэдэн мянган шүтлэгтэн, мөргөлчин ном эрдмийн олон зуун шавь нарынхаа хайр хүндэтгэлийг хүлээн, бишрэн шүтэгдэж байсан нь намтар түүхнээ бичигдэн үлджээ.

Нэгэн зүйл “Цахарын дал наяд хүн Нэйж тойны саатаж бүхүй ууланд ан хийж явахуйд, гурван хүн ундаасч ус эрж явсаар хадны хонгилоос утаа гарахыг үзээд даяанч байна гэж бодон тэнд иржээ. Агуйд орон ламд мөргөхөд хутагт бээр “та нар юунд яваа улс вэ?” гэхэд тэд хариуд нь “бид болвоос анчин билээ • эдүгээ ламд мөргөхөөр ирэв” гэсэнд хутагт зарлиг болруун “та нар ундаасав уу?” гэхэд анчид “ихэд ундаасав” гэлээ. Хутагт бээр Арьяандэв нэрт шавиа

¹²⁵ “Manzhusiri dalai boyda nej toinii tsadig ba maytayal yurban turul boloyson-u jalbiral mashi batu oroshil-un shilug-luge nigene magyd tuy-un oroi dehi erhe-ien hayan hemehu oroshibai” судар. модон бар. 6 хуудас

дуудаж “чанасан цайнаас эдэнд ханатал уулга” гэсэнд шавь бодруун “энэ ганц шанаганд чанасан цайг хэдий их гэж энэ мэт зарлиг болно вэ” гээд багшийн зарлигийг даган тэдэнд цайг ханатал уулгав. Түүнээс хутагт бээр “та нарт нөхөд бий юу?” гэж асуухуй дор “бид дал наяуулаа” гэв. “Тэгвэл тэднийг ирүүлж энэ цайнаас уулга” гэсэнд тэд өчрүүн “ламын энэ цайны сав өчүүхэн манай нөхөд олон тул яаж хүрэх вэ” гэхэд багш бээр “гэмгүй ирүүлтүгэй” гэсэн дор тэд явж нөхдөө авч ирэн бүгдээр нөгөө цайнаас ханатал уусан боловч цай өчүүхэн дундарсангүй, анчид хутагт гэгээний ид шидийг ихэд гайхан сүслэн мөргөв. Үүнээс хутагт тэдгээр анчид дор зарлиг болруун “та нар энэ ууланд ан бүү хий” гэснээр анчид тэр үеэс тэнд ан хийхийг болив.”¹²⁶

Нэгэн зүйл “Бээжин орохоор аянд яваа өөлдийн хэсэг хүн түм шахам адуу тууж Хуйвь хэмээх газар хүрээд, ус эс олдон хүн мал бүгд ундаасан зүг бүрт ус эрсэн авч олж чадалгүй ангаж байв. Хэдэн хүн элсэнд суугаа ламыг гэнэт үзээд “элчилгүй газарт суугч энэ нь хүн юм уу? чөтгөр үү? газрын эзэн юм уу?” гэлцэн дэргэд нь хүрвэй. Лам хүн байхыг харан мөргөж учир байдлаа хэлэхүйд хутагт бээр “тэгвэл бусад нөхөд дээрээ очиж гэрээ барихын урьд тогоогоо тавь, та нарт ус олдоно” гэжээ. Тэд буцаж очоод нөхөддөө үүнийг ярьж, хутагтын айлдсан ёсоор үйлдэв. Тэр даруй их хур орж хүн мал бүгдийг цангааг тайлав. Тэдгээр улс баярлалдан “энэ лам бидний амийг аварлаа ламд адуунаас өргөө” гэж айлдсанд, хутагт “над морь хэрэггүй” гэв. Тэдгээр өглөгийн эзэд дахин, дахин авахыг гуйсанд “тэгвэл тэр хар азаргыг өгтүгэй” гэхэд, азарганы эзэн болгоомжлон “түүнийг та хэрэглэж үл болно, төрснөөс нь хойш түүний нуруун дээр гагц тэнгэрийн хур дуссанаас бус хүн амьтан дээр нь гараагүй билээ” гэхэд Нэйж тойн тэр азаргыг зайдан унаад одов. Хожим нэг газар хүрээд хутагт морийг эргүүлж тавьсанд тэр нь ижилдээ очиж нийлсэн ажээ”.

Нэйж тойн өөрийн үзэл номлолыг хөгжүүлэх дэлгэрүүлэх хөрс суурь, нөөц боломжийг хүмүүсийн итгэл, сэтгэлийн өргөлөөр эргүүлэн үйлдэж, өөрийгөө хувиа хичээгч, ашгийн төлөө тэмцэгч биш, үнэхээр буяны садан, хүсэлт орчлонгийн шуналын хүлээсээс ангижирсан нэгэн болохыг нотлон харуулж байна. Тойн хутагт бээр хүмүүст номын өглөг, эдийн өглөг хоёрыг харамгүй хайрлаж, олон сүм хийд байгуулан, монгол ном сургаалаа сурталчилж, бусдын тусын тулд зорьсон их зорилгоо хувийн эрх ашгаас дээгүүр тавьж, түүнээ нийгмийн өмнө танигдахуйцаар харуулж, өөрөө үлгэрлэн биечлэн оролцож олон шавь, дагалдагсдыг удирдан сургаж, итгэл үнэмшил сүсэг бишрэлийг батжуулж, номлол суртгаалаа хойч үе, хожмын залгамжлах уламжлалыг маш тогтвортой болгож чаджээ.

Нэгэн зүйл Нэйж тойн “найманд хүрч тэр хошууны Хунбаатар вангийн орвол ван ламыг нэгэн бадарчин тэнүүчилж явна хэмээн сэтгээд хөөжээ. Нэйж тойн “ван намайг үл таних нь зөв, харин энэ алтан Зонхова намайг танилтай

¹²⁶ “Богд Нэйж тойн далай манзуширийн домгыг тодорхой гийгүүлэгч чандмань эрхи хэмээгдэх оршив”

билээ” гэсэнд хойморт залаатай Богд Зонховын алтан цутгамал дүр мишээв. Түүнээс ван хутагтыг эгэл биш лам болохыг мэдэн биширч мөргөв”¹²⁷.

“Эфү банди ван, Амба гүнж хоёр Нэйж тойноос үрийн хутаг гуйж гэртээ залав. Таван сайн булга сэлтийг Гүнж өөрөө барьж мөргөсөнд дөрвөн булга нь ламын зүг хандаж, нэг булга нь Гүнжийн хумсанд торж гэдрэг унасанд түүнийг аваад ламд өгөх гэхэд хутагт бээр “байтугай, бэлгэ зохив. Дөрвөн булга миний зүг хандсан нь дөрвөн хөвгүүн болохын бэлгэ. Нэг нь Гүнжийн зүг хандсан нь нэгэн охин болохын бэлгэ” гэв. Ван Гүнж хоёр баясч бишрэв. Хойно үнэхээр дөрвөн хүү, нэг охин төрсөн ажээ”.¹²⁸ Мөн “Түшээт ханы нутагт залрах үед нь тайж Баясхалын хатан үрийн заяа гуйхад үрийн хутаг хайрлав.

Хойно Нэйж тойн хутагт Омбу хунтайжийнд ирэхэд, тайжтан түшмэдээ цуглуулан найрлаж суувай. Ламыг үзээд зуудаг хоёр нохойгоо тавиулахад ноход нь ламын дэргэд очоод сүүлээ шарвалзуулан эрхлэв. Омбу хунтайж “энэ лам эгэл бус хүн байна нааш ирүүл” гэсэнд хиа нар нь хутагтын залж дэргэд нь суулгав. Хунтайж зарц нараа захиран “энэ ламд зооглох идээ өг” гэсэнд тэд хонь үхрийн мах авчирч өгсөнд лам тэр их махыг бүгдийг нь зооглов. Тэнд байсан улс маш их бишрэл төрөв”.

Нэйж тойн мэдлэгийн амьд хэрэглээг бий болгож, оюуны хэрэгцээ хүмүүсийн хүсэл эрмэлзлэлийг хэн ч урьд нь хангаж чадаагүй өндөр төвшинд үзүүлж чадсан нь түүний амжилтыг тодорхойлж байна. Нэйж тойн хүмүүсийн хүссэн цагт бороо оруулж, үр хүүхэдтэй болох хүслийг гуйсан мөргөсөн цагт нь биелүүлж, нүдгүй хүнд хараа оруулж, цангасан улсыг үхлээс аварч, тэр байтугай өөрийг нь зуулгахаар турхирсан ярдаг нохдыг хүртэл хөлийнхөө дор эрхлүүлэн шарвалзуулж байгаа нь үзсэн харсан, уулзсан учирсан бүхний гайхширлыг төрүүлж, өөрийн эрхгүй сүслэн бишрэх, тэдний хайр хүндэтгэлийг хүлээх болсныг харуулж байна.

Хөх хотын орчим гурван сар их ган болсонд хөх хотын дөрвөн даяанч, богд Цагаан лам, монгол Равжамба, Аюуш гүүш нар хур оруулах зан үйл үйлдсэн боловч эс бүтэв. Омбу хунтайж богд Цагаан гэгээнд айлтгасан нь “ламаа амьтны хувь доройтов уу? яагаад ийм их ган болов?” гэсэнд богд Цагаан лам зарлиг болруун “Авга харын агуйн өвгөн ламд мэдүүлвээс тэр хур оруулж чадах буй за” гэв. Омбу хунтайж элч зарж “бороо жадал” гэж хэлүүлэв. Тойн хутагт хариуд нь “над тийм урт жад байхгүй ноён тэнгэрт хүрэх жад илгээ” хэмээв. Богд цагаан лам хунтайжид хэлсэн нь “та буруу айлтгажээ, бороо гуйнам хэмээн мэдүүл” гэв. Хунтайж ихэд баясч хатнаасаа нэг торго авч, нэгэн хиаг элчээр илгээв. Хиа яаран агуйд хүрч агуйн хаалгачад мэдүүлэв. “хөх хотын газар ган болсон тул Омбу хунтайж ламаас хур гуйлгахаар намайг илгээв” гэсэнд хаалгач лам, хутагтын дэргэд очин энэ учрыг айлтгасанд, Нэйж тойн тэр элчийн нэр, авчирсан бэлгийг асуулгав. Элчийн нэр Долоодой авч ирсэн бэлэг

¹²⁷ “Монголын уран зохиолын тойм” II боть. УБ. 1977., 244 дэх тал

¹²⁸ “Монголын уран зохиолын тойм” II боть. УБ. 1977., 245 дахь тал

торго байсанд “элчийн нэр долоодой бөгөөс, торго нь зуурмагтай байна. Нэрийн бэлгээр долоо хоног хур ортугай” гээд цааш “ноёндoo хэл, энэ голын аман дахь улс ба доор нутагт улсыг нүүлгэ, үер бууж болзошгүй хурдан харь гэв”. Хиа бээр буцан ирж хунтайжид хутагтын хэлснийг айлтгав. Хунтайж “торго нь зуурмагтай гэж юу юм бол?” хэмээн хатнаасаа асуусанд хатан инээгээд “тэр торго уул нь бүхэл байсан юм, түүнээс аяганы гэр хийх гэж нэг ам цуулж авсаны тул тэгж айлдсан бизээ” гэв. Ноён маш баясаад голын ам ба доод биеэр нутагтай улсыг нүү гэж зарлав. Зарим улс “манай ихэс лам нар хур оруулж эс чадсан юм, энэ хөгшин лам яаж чадах вэ дээ” гэж үл тоомсорлов. Түүнээс их үер бууж бүгд гайхан бишрэв.

Тэндээс Түшээд хааны хошуунд хүрэв. Тэнд нэгэн мэргэн удган нүд нь сохроод, өлбөрч үхэхээр шийдээд хөдөө хэвтэхэд нь хоёр шавь нь авчирч хутагтад үзүүлэв. Нэйж тойн түүнийг номын увидсаар эдгээсэнд удган биширч, Түшээт хаанд очиж ламыг магтав. Хаан сорьж үзээд сүүлдээ биширч шавь оров. Бөө удган нарын тэнгэр онгоныг нь тэвчүүлж, хүмүүсийг урамшуулан шагнах журмаар сүсэгтнийг олшруулав. Нэйж тойны зарлигаар тэндэхийн ноёд зүг бүрт элч илгээж бөө удганы онгоныг цуглуулан авчруулав. Түүнийг нь дөрвөн ханат гэрийн чинээ овоолж шатаав. Нэйж тойныг цааш явахад Жалайд хошууны Лянхуа дархан хошууч ноён тэргүүтэн хүмүүс угтан авч залав. Лам тэдэнд ном номлоход ордны гадуурх бургаасан хашаа навчилж ургав. Лам хар хүмүүс олноор бишрэн шавь болов.

Нэйж тойныг очсон газар орны эрдэм номтой хүмүүс, язгууртан дээдэс үл ойшоох байдлаар угтаж байлаа. Харин ном эрдэм, үзэх үзэл, бүтээхүй чадвараар илүү гэдгийг нь ойлгож мэдмэгц бүгд бишрэн хүндэлж, түүнтэй ойр байх, ивээлд нь багтахыг эрмэлзэж эхэлж байгаа нь илт байна. Архад мэргэн даяанч лам Нэйж тойны их хүн болохыг мэдээд хүндэтгэн, өөрийн сэнтийдээ залж, гайхамшигт Богд ламтан та намайг өршөөж хайрла, бардам зан, сэхүүн байдалдаа автан таныг үл тоомжирлож, гайхамшигт Богдтон болохыг таньж мэдсэнгүй. Одоо нүглээ наманчилъя хэмээн олонтоо мөргөж байгаа тэргүүтэн жишээг дурьдахад Тойн хутагтын эгэл даруу байдал, эрдэм номынх нь чадал, алдар суу аяндаа ойлгогдоно.

Нэйж тойн монголд бурханы шашин гуравдахь удаа дэлгэрэхэд хүндтэй үүрэг гүйцэтгэсэн бурханы шашны томоохон төлөөлөгч мөн болно. Тэрээр бөө мөргөлийг бурханы шашнаар солиход өөрийн үйл ажиллагаагаар ихээхэн түлхэц үзүүлсэн юм. Онигуудын хатан бие чилээрхэж, нэгэн ховс бөөг залахаар элч зарав. Энэ үед Нэйж тойн тэднийд ирж хатныг эдгээв. Тэд баярлан хорооноос гадна нэг гэр барьж өглөө. Бөө ирээд хутагтад хорсох атаа төрөн, цагаан азаргаа унан гэр лүү нь хэд хэд довтолоход аянга нижгэнэн үер буув. Бөө ламынд орвол хутагт аянгын бүх сумыг орхимжиндоо боочихоод сууж байснаа үзүүлэв. Бөөгийн хэл нь зуурч, татвалзан хөсөр унав. Тойн хутагт

зүрхэн тушаа тарнидахад хамраас нь могой гарч идгэв. Бөө ламын увидаст гартан, шавь орж увшийн санваар авчээ. Нутгийн улс амьтан хутагт гэгээнийг бишрэв.

Тойн хутагт бөө нартай хайр найргүй тэмцэж байгаа хэр нь бөөгийн чадварыг ухаалгаар хэрэглэж буй нь түүний амжилтыг улам ч бататгаж байна. Заримдаа тэрээр бөө нарыг ад шоо үзэлгүйгээр тэднийг авран тусалж, увидас шидийг үзүүлж байгаагаараа хүмүүст өмнөх ойлголт, бишрэл үнэмшлээ хадгалах, үзэл номлолуудын ойр талуудыг ойлгох боломжийг олгож, бөө мөргөлийг эрхэмлэх үзлийг нь шууд бусниулан үймүүлэх биш, харин түүнээс хавьгүй илүү төгс чадварын дэргэд юу ч биш болох ба чухамхүү тийм чадварыг хүндэтгэх, түүнд дагаар орох учиртай гэдгийг харьцуулан үзэх, бодож ухаарах боломжийг олгож байна. Бөөгийн үер бороо оруулж, аянга цахилгаан буулгаж байгаа чадварыг мөн түүнтэй л адил үзүүлэхийн сацуу өөрөө егүзэр хүн учир бөөгийн увидаст автахгүй байж чадна гэдгээ харуулан түүний ниргэсэн аянганы сумыг буцаан өгч, тарнийн үг хэлэх төдийд бөө хэлгүй дүлий болж, түүнд шингэсэн муу ёрын сүнс сүүдрийг арилган тусалж байгаа нь хэдийгээр үлгэр домгийн шинжтэй боловч чадалтныг илүү чадал чадвараар дийлж буйг ойлгуулж байгаагаараа чухал юм.

Манзушир далай богд Нэйж тойн хутагт бээр Чойжи-Одсэр бандидагийн үеэс хойш үед цагийн эрхээр тасраад байсан монгол уншлагын уламжлалыг сэргээн судар тарнийн олон арван судар номыг орчуулан тархаах, өөрөө монгол номоо гол болгон бясалгал бүтээл хийн, үлгэрлэн үзүүлж монголоор ном хурах журмыг асар дэлгэр номлон тогтоож, монголын гэх онцлогтой ер бус бурхан шашныг дэлгэрүүлснээр энэ зүгийн хувь төгөлдөр номхотгуун дор монголын өөрийн хэлээр шашны нарийн нууц номыг сурч сонсох, бясалгах увидасыг соёрхон, бурхан багшийн номлол сургаалыг манай монгол хэлээр илэрхий номлон, монгол уншлагын үндсийн тавьсан гэж хэлэх бүрэн үндэстэй юм.

“Сурвалж бичигт үүнийг”... Манай энэ монгол дор төгс цогт Сажа номын хан хутагт түгдэм үсэг гаргаж, бичиг уншлага сургаад, монгол мэргэд богд нар зарлиг хийгээд шастирыг орчуулан зохион тайлбарлан номлосон нь цаглаш үгүй олон” хэмээн монгол уншлагын уламжлал эртний түүх уламжлалтай гэдгийг тодорхой нотлон өгүүлээд цааш нь “...цагийн эрх болоод номын номлол сонсгол цөлүйдэгсэн үе дор богд лам Нэйж тойн залран ирээд монгол манай будан харанхуйг гийгүүлэн бурхан багшийн шашныг наран мэт болгов.”¹²⁹ хэмээн Нэйж тойн хутагтын монголоор ном дэлгэрүүлэн шашин амьтны тусыг агуу ихэд үйлдэн, бурханы шашныг монгол оронд дэлгэрүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэснийг дүгнэн үгүүлжээ.

- Нэйж тойн хутагт “...Энэ Богд лам нь эрт энэтхэгийн шашин төвдөд өөрийн хэлээр ихэд дэлгэрсэн ба төвдөөс зарим монголд урьд шашин дэлгэрсэн боловч өөрийн хэлээр бус төвд хэлээр дэлгэрүүлбээс тэр нь санах бясалгахад хурц бус, доор оюунтан юуныг ч бээр мэдэх үгүй, эс мэдсэнээр

¹²⁹ Мэргэн гэгээний бум зарлиг оршвой 1-р боть, “Зохиолын тэмдэг бичиг” 2 хуудас

сүсэг ухаан илт төрөх бэрх хэмээн айлдан, тэнгэрийн хэл хийгээд лусын хэл ба зангийн хэл, гүнбэндагийн хэл хийгээд хүмүүний хэл нугууд ба хамаг амьтны дуун нугууд хэдий чинээхэн бөгөөс хамгийн хэлээр номыг үзүүлсүгэй”¹³⁰ хэмээн зорин чармайсан юм. Анх Энэтхэгээс үүсэлтэй бурханы шашны номлол ёсыг аль үндэстэн угсаатан тус тусын хэлээрээ дэлгэрүүлж болно гэж үзээд монгол оронд уламжлагдаж ирсэн бурханы шашныг эрхбиш монгол үг хэл, үсэг бичгээр дэлгэрүүлэх хэрэгтэй тэгж байж бурханы шашны мөн чанар, номын мөн чанар, хуврагийн мөн чанарыг ухааран, сая үнэн сүсэгтэн олноор нэмэгдэн, улмаар бурхан шашин улам дэлгэрэх учиртай, өөрөөр хэлбэл өнөө үед яригдах болсон мухар сүсэг бишрэлийг биш ухамсартай сүсэг бишрэлийг дэлгэрүүлэх хэрэгтэй хэмээн цөхрөлтгүй чармайн зүтгэж, ухуулан айлдаж байжээ.

Манзушир далай богд Нэйж тойн бээр өөрийн төрөлх монгол хэлээр ном дэлгэх зорилтоо биелүүлэхийн тулд асар их эсэргүүцэл саад бэрхшээлийг даван туулж, тэр бүхэнд цуцалтгүйгээр тэмцэн зүтгэж “.. үзэх сурах зарлиг шастир ба сонсох санахын хөтөлбөр ба бясалгах оногдохын увидас ба дөрвөн аймаг үндэсний мэдлийн цөөнх ба хоёр зэргийн их мөр хийгээд номын сахиулсны хангал наманчлал тэргүүтний амны уншлага бүхнийг шударгадан унших ба яруу эгшиглэн үйлдэх, сүрхий аялгуулан үйлдэх ба гарын авлага цан хэнгэрэг дэлдэхээс дээш алимадыг цөм монгол хэлний зохиолоор урьд үгүйг зохиож дэлгэрүүлэн ямандагын сахиулсан эрлэг номун хаанаа хаджээ”¹³¹ их амжилт бүтээлд хүрсэн юм. Түүний энэ их үйлдэл, монгол шашныг буй болгон бүтээж чадсан агуу туурвил сэлтийг, шашин номын үүднээс авч хэлвэл ямартай ч эгэл хүмүүн, жирийн лам хүний хэвчээнээс хол илүү, нууц тарнийн шидийг олсон хүний хийх ажил гэж үзнэ.

Түүний амьдралын зарим нэг үйлдэл өөрөөр хэлбэл шашны ёсонд энэ үйлийг жирийн лам нар хийх ажил, энэ ажил бол хувилгаан хүний хийх ажил гэдэг нэг тийм тогтсон ойлголт байдгаас үүдэн ойлгож болно. Ялангуяа түүнийг “ямандагийн егүзэр” гэх ба лам ямандагт харшлаа гэх буюу Мэргэн гэгээний магтаалд “ямандагийн биед тоорхой үзүүлсэн” гэх зэрэг магтаал бол жирийн ламыг ингэж дуудвал хүнддэнэ гэх итгэл үнэмшил байдаг, их бага арван ухаанд цагаарсан лам нарч бас хэн нэгнийг дур тааваараа нэр өгдөг ёс байдаггүй зэргийг иш болгон үзэх. Мөн зарлиг шастир ба сонсох санахын хөтөлбөр, бясалгах оногдохын увидас ба дөрвөн аймаг үндэс хийгээд хоёр зэргийн их мөр хийгээд номын сахиулсны хангал наманчилал тэргүүтний амны уншлага бүхнийг шулуун унших ба яруу эгшиглэн үйлдэх, аялгуулан үйлдэх ба мутарлага, цан хэнгэрэг дэлдэхээс дээш алимадыг цөм монгол хэлний зохиолоор зохиож чадна гэдэг бол жирийн уран зохиолч, шашны зүтгэлтэн, яруу найрагч юмуу ер нь хэн дуртай хүн хийж чадах ажил биш гэдэг нь ойлгомжтой зэргээс үндэслэхэд Нэйж тойн бол нэгэн богд эгэл бус хувилгаан, нууц тарнийн

¹³⁰ Галданваанчигдож “Мэргэн хийдийн уг түүх оршивой” Б.Мөнх тайлбарлав. СХХ. 1994., 37 дахь тал

¹³¹ Хурцбилэг “мэргэн сүмийн монгол уншлагын уг үүсэл түүний ач холбогдол” Мэргэн гэгээн судлалын үгүүлэлүүд. СХХ. 1997., 267-р тал. Дам ишлэв

бүтээлийг олсон, монголын шашны түүхнээ ховорхон тохиолдсон их егүзэрва байсныг хүлээн зөвшөөрөх зүйтэй юм. Ер нь яагаад монголын шашны түүхнээ монгол хэлээр ном номлох, эх хэлээр шашин дэлгэрүүлэхийг тийм олон хүн хийж чадаагүй нь бас нэг талаар энэ нь хүчир хүнд ажиллагаа болох учир дор болов уу.

Зарим судлаачид Өвөр монголын зүүн хэсгийн Хорчин, Харчин, Түмэд зэрэг аймгууд нь соёлын талаар нэлээд хөгжсөнийг, ялангуяа XVII зуунаас хойш энэ нутагт их эрдэмтэн зохиолчид хийгээд соёлын зүтгэлтнүүд олноор төрөн гарсны шалтгааныг Нэйж тойн хутагтын хүчин чармайлт, соёлын үйл ажиллагаатай холбон үзэж, “суурийн чулууг талбисан юм уу үндэслэгчийн нэгэн”¹³² гэж үнэлэх саналыг дэвшүүлсэн байна.

Мэргэн гэгээн бээр Нэйж тойны шашин номыг монголоор дэлгэрүүлснийг сайшаан Богд лам Нэйж тойн залран ирээд манай монголд бурханы шашныг наран мэт болговай. Ялангуяа тарнийн ном, тод замын ёсыг мөнхүү манай хэлээр ухуулан заасан тэр журам дагаж уншигчин хийгээд үзэгчин сурагчин ба номлогчин маш их дэлгэрэв.¹³³ хэмээгээд түүний энэ агуу үйлийг Ямандагийн бүтээлийн арга судрын төгсгөл үгэнд:

“Хэтэрхий Ямандагийн егүүзэр богд Нэйж тойны гэгээн бээр

Хэлэх шашин хийгээд амьтны тус жаргаланг сэтгэж

Их нигүүсэхүй бээр амьтан нугуудыг ялгаж

Тус бүрийн хэлэн лүгээ зохилдуулваас

Илэрхий оюун дор ном хялбар төрж

Ямагт сэтгэл дор тус болохуйг шүтэж

Энэ орноо эс алдаршсан гүн нарийн

Нууц тарни очирт хөлгөнөөс

Ихэд очир аюулгагч арван гурван бурхантын

Бүтээлийн аргыг эн олон номлож шашин хийгээд

Амьтны тусыг эндүүрэл үгүй агуу ихэд үйлдлэгэ”¹³⁴ хэмээн түүний тарнийн гүн нарийн увидас нугуудыг олон жилийн бясалгал даяанд суун бүтээгээд, элдэв шидийн үүдийг нээн, бурхан болох тод замыг тодорхой монголчилон гаргаж заасны ач тусыг өгүүлээд бишрэн дээдэлж ийнхүү бас магтжээ.

Маш олон судар тарнийн таалсан утгыг

Манзушира Лувсандагвын зохиосон журмыг

Манай монгол хэлэн иеэр илэрхий еэ номлогсон

Магад их ачтадаа залбаримой адисла”¹³⁵ гэжээ.

Нэйж тойн бурханы шашны номлол сургаалыг заавал төвд хэлээр урих албагүй бөгөөд харин ямар үндэстэн бол тэр үндэснийхээ хэлээр дэлгэрүүлж

¹³² В.Хайссиг. Монголын шашин суртахуун. Хөх хот., 1998., 183-р тал.

¹³³ Очирдарь мэргэн даяанч ламын гэгээний бум зарлиг оршвой 1-р боть 12 бүлэг

¹³⁴ “Eihe tsogtu vcir ayulgugci arban gurban burhantu-en butuhel-un arga hemegdehu orosibai”

¹³⁵ Мэргэн гэгээн “Manzhusiri dalai boyda neij toinii tsadig ba maytayal yurban turul boloyson-u jalbiral mashi batu oroshil-un shilug-luge nigene magyd tuy-un oroi dehi erhe-ien hayan hemehu oroshibai” судар. модон бар. 6 хуудас

болно хэмээн үзэж, төрөлх монгол хэлээрээ урих зан үйлийг тийнхүү тогтоож мөрдүүлсэн юм. Энэ тухай гүүш Ариундалай "...монгол улсын эзэд ноёд өчүүхэн хаад олон болж, төр самуурсан нь нэгэн этгээд эв эетэй тогтжээ. Улс иргэн самуурахуйд цагаан зүгийн тэнгэр лус хямарсан ахуй харшийн нөхцөл үгүй зохилджээ. Монгол хэлнээ орчуулсан номыг орчуулагч гүүш нар, бурханыг урлагч уран зураач, бичээч, өвчин зовлонгоос арилгагч эмч нар, олон зүйлийн эрдэмтэн энэ богдыг шүтжээ. Хар зүгийг таалагч тэнгэр лус ноёд сайдын биет ба онгод чөдөр бөө удган хийгээд хуучин ёсны шашныг тэтгэн баригч нугууд цагаар цөм буруудан өнгөрчээ. Товчилбоос төр шашны байдал ихэд зохирч, хүмүүн лүгээ учралын арван найман ном бүгд бүрдээд, гурван гэмт савыг тэвчиж, зургаан хуран мэдэхүйт болсон сайн нөхцөл илт болсон"¹³⁶ гэж түүнийг үйл ажиллагааг үнэлэн тэмдэглэсэн байна.

Нэйж тойн хутагт монгол түмэндээ өөрийн төрөлх хэлээрээ ном дэлгэж, ном эрдмийн ачийг илэрхийлэе үзүүлэн явснаар өргөн олны хайр хүндлэлийг хүлээн "Манзушир далай богд", "Хоёрдугаар богд лам", "Богд тойн гэгээн", "Ямандагийн егүзэр" "Тойн хутагт" тэргүүтэн эрхэм цолыг олж байжээ. Тойн гэгээн бээр ийн монгол уншлагыг урьд өмнө үгүйг системчилэн хөгжүүлнээс "энэ богдын шашин далай мэт дэлгэрэн сүсэгтэн өглөгийн эзэд шавь нар газар дээр бүрхэн" түүний энэ эх соёлоо авран хамгаалах, үндэсний хэлээр ном хурах, монгол уншлагыг хөгжүүлэх, зорилт нь маш их амжилтанд хүрч чадсан байна.

Мөн Нэйж тойн бээр бөөгийн шашин шүтсээр байсныг хориглож, мах цусаар бөө онгодыг тахин шүтэх явдал нь энэ хойт хоёр насанд ямар ч хэрэггүй бөгөөд их хорлолтой болох тул тэр шүтлэгээ орхиж, лам гурван эрдэнийг шүтэх хэрэгтэй гэж ухуулан зарлиг гаргаж, зүг зүгт илч илгээж, хамаг онгодын дүрсийг хураалгажээ. Тэд ч өөрийн шүтээн онгодоо сүйтгүүлчээд зүгээр суух хүлцэнгүй улс биш ба, бас хар зүгийн бөөгийн тухирлага, хараал жатга муу үйлдэлгэ ихээр хийж байсан ч түүнд авталгүй тэр бүхнийг үрчин бадмын хүчин мэт агуу хүчин рид хувилгаанаар хариулан чадсанаар барахгүй тэднийг огоот гэсгээн, номхруулж сахил санваар хүртээн тангараг дор тальбин, шашны үүднээ оруулсан охь тарни баригч их бүтээлчин юм.

Хорчины ван Түшээт ханы нутгаар төв болгож, шашин ном дэлгэрүүлэхдээ монголоор урих ёсыг чанд тогтоож, 60 гаруй бандийг шалгаруулан шавь болгоод "Арван гурван бурхант Очир аюулгагч", "Нууцын хураангуй", "Итгэл", "Ямандаг"-ийн ван тэргүүтэн олон зүйлийн ван жинан хийгээд Очирваанийн бясалгал, Ямандагийн үүсгэл, төгсгөлийн хөтөлбөр, сэтгэшгүйн хөтөлбөр, Ламын ёго, эш удирдуулсан хөтөлбөр сэлтийн бүтээлийн арга зэргийг цээжлүүлэн бясалгалд сургажээ.

¹³⁶ "Дорно-хи шашны зул богд Нэйжтойн ламын шинийн дуут намтар" модон барын хэвлэл
Хурцбилэг "мэргэн сүмийн монгол уншлагын уг үүсэл түүний ач холбогдол" Мэргэн гэгээн судлалын
үгүүлүүд. СХХ. 1997., 267-р тал

Тийн монголоор ном урих дэгийг дэлгэрүүлэхдээ эдийн урамшуулалыг ч сэжиглэлгүй ашиглаж “Ямандаг цээжилсэнд нижгээд лан алт хийгээд Нууц хураангуйн бүтээлийн арга ба үндсийг цээжлэгсэд дор нэжгээд лан алт хийгээд үгээгүй ядууст эд таваар хийгээд мал адгуус элдэв алиныг хүссэний ёсоор өгсөнд ер ямандаг, нууц хураангуй цээжлэгчид маш олон болжээ”¹³⁷.

Нэйж тойн хутагт ван гүнгээс эхлэн ноёд, түшмэд, хатад авхай нар хийгээд бусад олон өглөгийн эзэн, шүтлэгтэн сүсэгтэд, лам хувраг нарт хүссэн ёсоор нь убашаи, убсанз, тойн гэнэн, гэцэл, гэлэн, сахил, ангид, тонилгогч найман санваар зэргийг хүртээж, Хорчин, Харчин, Түмэд, Найман, Онигуд, Хишигтэн, Баарин, Ар хорчин, Дөрвөд, Жаруд, Жалайд, Горлос зэрэг олон хошууны сүсэгтэн олны хүндэтгэлийг олж, монгол номын уншлагын дэг нэгэнт тогтож, сүм хийд, лам хувраг олшрон, монголжуу болгон шинэтгэсэн бурханы шашин өмнөд монголын зүүн хэсэгт үлэмж дэлгэрчээ. Энэхүү арван хошууны шашны гол төв нь Хорчины түшээт хан өглөгийн эзэн болж, Нэйж тойны байгуулсан Баянхошууны хийд болж байсан бөгөөд тэр үеэс өдгөө хүртэл монгол уншлагын дэгийн дагуу номоо урьсаар иржээ. Энэ тухай Нэйж тойны номын шавь нарын нэг Баарин лам Дармадала бээр “...Баян хошууны хийдэд заларч лам өөрөө шавь нарын хамт ламрим, ложон тэргүүтэн олон номыг монгол хэлэнд орчуулжээ. Зүг зүгээсээ цугларсан олон шавь нарт гэлэн, гэцлийн санваарыг хайрлаж, олон хуврагаар гурван санваарын эзэн болгожээ. Шашинд орохын гагц үүд болох итгэл ба мэгзэм, мандал, базарсадын бясалгал тэргүүтэн олон номыг хайрлаж, боловсрол нирвааны сайн замд байгуулжээ. Зүг зүгт хийд дацан олныг байгуулж, тэдгээрт цагаан сарын ерөөл, майдар эргэх тэргүүтэн ба хурлын уншлага, хурлын ёс журам тэргүүтнийг сайн зохион байгуулжээ. Хурлын уншлага хангал, магтаал зэргийг монгол хэлээр болгож тэдгээрийн ян, дан, хэнгэрэг, цан цохилт тэргүүтнийг дэглэжээ. Сүүлд ихэнх монгол оронд төвд хэлний уншлага үлэмж их дэлгэрсэний шалтгаанаар тэр монгол хэлээр хурдаг зуршил ихэнх нь мөхсөн боловч одоо түшээтийн Баянхошууны хийд тэргүүтэн Хорчины олон хийдүүдэд монгол хэлний уншлага хэвээр байна”¹³⁸ хэмээн тэмдэглэснээс тодорхой мэдэж болно.

Нэйж тойн Хөх хотод ирмэгц их Зуу сүмд номыг эх монгол хэлээрээ урьсанд тэнд байсан төвд хутагтуудын эсэргүүцэлтэй тулгарсан байна. Энэ байдлыг сайтар мэдрэн ойлгосон Хөх хотын Ширээт цорж лам Нэйж тойнд “...лам чи хамаг эрдмээ дотроо нуугаад үл мэдэхийн дүрээр барьж, энэ мэт явдлаар явбаас чамайг тайгчин үгүй бөгөөд амьтанд тус болохоос хор болохын гэм буйн тул үүгээр амьтныг туслагтугай”¹³⁹ хэмээн сануулан айлдсан ажээ.

“Богд Нэйж тойн Манзуширийн домгийг тодорхой гийгүүлэгч чандманийн эрихэ” хэмээх намтарт нь өгүүлсэнээр “шашныг дэлгэрүүлэхийн бэлгэ зохиох”

¹³⁷ Мөн тэнд., 43 дахь тал

¹³⁸ Дармадала. Их Монголын оронд дээдийн ном ямар мэт дэлгэрсэн ёсныг тодорхой өгүүлэгч цагаан лянхуан эрхис хэмээх орвой. Орчуулсан номч мэргэн гавж С.Гомбожав. УБ., 1995., 201 дэх тал.

¹³⁹ “Богд Нэйж тойн далай манзуширийн домогийг тодорхой гийгүүлэгч чандмань эрхи оршивой”

өөрөөр хэлбэл Манжийн хааны зөвшөөрлийг олохын тул Мүгдэнд очиж бараалхахад нь Манжийн эзэн хаан Амбага хун тайж түүнийг тахилын ламаа болгож, Мүгдэнд тусгаар сүм байгуулж өгөхийг санал болгосонд тэрбээр "Богд эзэн хэмээвээс дэлхий дахинаа их хаан, би хэмээвээс орд ордыг (орон орныг) бядагч өчүүхэн даяанч болоод эзнээ тахигдахуйд эзний их алдарт тун таагүй"¹⁴⁰ хэмээн эгэл даруу лам хүний ёсоор эвтэйхэн аргалаад, хааны хишиг соёрхолыг ч хүртэлгүй хорчин нутгийн зүг одсон тухай өгүүлж байна. XVII зууны эхэн үед шарын шашин хараахан дэлгэрлийг олоогүй аймаг бол Хорчин, Харчины нутаг байсан тэрээр энэ нутагт бурханы шашныг монгол дэг ёсны дагуу дэлгэрүүлэх зорилготой байсан нь түүний хожмын үйл ажиллагаанаас мэдэгдэнэ. Тэрбээр Содномжамц Далай лам, Алтан хан хоёрын үед анх бүтээсэн бага Зуу хийдийн шинэтгэн, шүтээн сүмийн хамтаар хуучирсныг сэлбэн засуулсаны дээр амьдралынхаа сүүлийн жилүүдийг Урад, муу мянган, хорь түмэдийн нутаг, мөн халхын түшээт ханы нутаг тэргүүтэн олон газрыг бядан явж заларч, сүм хийд байгуулан, өөрийн эрдэм номын ид шидээр олон түмэн монголчууддаа алагчлал үгүй туслан, тэдэнд өөрсдийнх нь мэдэх эх хэлээр нь ном талбиж, өөрийн дэг ёсны дагуу хурал аймаг тогтоож, бат орон болгон, шашныг бататган дэлгэрүүлэхэд зориулжээ.

Герман улсын нэрт эрдэмтэн В.Хайссиг абугай "...хамгийн эгэл ардууд эн тэргүүнээ мал услаж аргал түүдэг тэдгээр хүмүүс түүнийг хамгаас илүү өргөн магтаж байжээ"¹⁴¹ хэмээн үнэлсэн нь оновчтой сайхан үнэлэлт юм.

Амьтны тусын тул тодорхой мандсан аврагч хоёрдугаар ялгуугсан богд тойн ламын, ариун шашныг дэлгэрүүлэх гэгээн үйлсийн алтан дуаз илэрхий мандан, төгс цогт ламын адистэдийн шимээр арван зүгтээ дэлгэрчээ. Арилсан бодийн мөрийн сэтгэл төгсч, ерөөлийн үгсээр тонилохуй дор хүрэн, эвдэрш үгүй очир биеийг олсон ч ерэн долоон насны арван сарын тэргэл өдөр олон тэмдэг билэг үзүүлэн таалал барьсан.

Сайны өлзий өгөгчийн өлмийн тоосноо шүтэн, ер бус монголын шашин наран мэт дэлгэрвэй. Ум сайн амгалан болтугай.

SUMMARY

Holiness Neij Avid /1557-1664/ is a monk who popularized the action to broadcast the sutras and books of Buddhist religion through the national writings, Language and culture in mother Language and do and read the religious teachings and ordinances in native Mongolian Language.

He was born as a son of Mergen Temnan, Lord of Torguud tribe of Durvun Oird.

Monk Neij was a disciple of IV Banchin-Erdene Luvsanchojijantsan of Tashilkhumbe, Tibetan monastery from 1570 through 1662 and worshiped many wise magicians and educated by religious education perfectly.

¹⁴⁰ Ц.П.Пурбуева "Биография Нейджи-тойна" источник по истории буддизма в Монголии 1964. С.78

Новосибирск

¹⁴¹ В.Хайссиг. Монголын шашин суртахуун. Хөх хот., 1998., 30 дахь тал.

Monk Neij left his home and out lived oppressiveness and meditated for 12 years in Mountain Avga khar, Inner Mongolia and for 23 years in cave of Shar Malgai /Yellow cap/ and totally 35 years in hard condition.

He meditated for long years and was enlightened perfectly and become holiness. Monk Neij is a one of the famous Buddhist religious representative who executed authoritative obligations when Buddhist religion was broadened in Mongolia. He was impulsive to change the Shamanism by Buddhism.

Manzushir Dalai Bogd Neij reached to extreme success and achievement overcame enormous obstacles and demonstrations in order to fulfill his objective to broaden the religious reading in Mongolian Language.

НОМ ЗҮЙ

1. Богд Зонхава "Бодь мөрийн зэрэг", УБ., 2006
2. "Богд Нэйж тойн далай манзуширийн домогийг тодорхой гийгүүлэгч чандмань эрхи оршивой" судар
3. Buddhism in Mongolia, Budapest., 1981
4. Галданваанчигдож "Мэргэн хийдийн уг түүх оршивой" Б.Мөнх тайлбарлав, СХХ. 1994
5. Дармадала, Их Монголын оронд дээдийн ном ямар мэт дэлгэрсэн ёсныг тодорхой өгүүлэгч цагаан лянхуан эрхис хэмээх оршивой.
6. Ц.Дамдинсүрэн "Монгол уран зохиолын дээж зуун билэг оршив" ,УБ., 1959
7. Жамбадорж "Болор толь", Өвөр Монгол, УХХ 1984
8. Ч. Жүгдэр, "Монголд феодализм тогтох үеийн нийгэм улстөр гүн ухааны сэтгэлгээ", УБ 1987
9. Зая бандидын намтар, СХХ 1998
10. "Зохиолын тэмдэг бичиг" 2хуудас модон барын судар. 12х31см
11. ШУА, ФСЭХ, "Буддын философийн түүхээс", УБ 1987 он
12. Лувсансамдүвням, "Цахар гэвшийн намтар", монгол бичээс хөрвүүлсэн акад. Д.Цэрэнсодном, док. Д.Наранцэцэг. УБ. 2010
13. Louis Ligeti, "Gatalogue du Kanjur Mongol Imprime", Budapest., 1967
14. ШУА, "Монголын уран зохиолын тойм" II боть, УБ., 1959
15. Б.Мөнх "Мэргэн гэгээн Лувсандамбийжанцан", СХХ 1995 он
16. "Мэргэд гарахын орон", Ринчингава, Сэцэнцогт эмхэтгэв, Өвөр Монгол, АХХ, 1983
17. "Мэргэн хийдийн уг түүх оршив" ред. Б.Мөнх, Өвөр Монгол, СХХ 1948
18. "Мэргэн гэгээн судлалын өгүүлэлүүд", Ред. Ү.Наранбат Б.Мөнх, Өвөр Монгол, СХХ 1997
19. А.М.Позднеев, "Очерки быта Буддийских монастырей и Буддийского Духовенства в Монголии", Улан- Удэ., 2000